



ОНЛАЙНААР НЭЭСЭН ДАНСАНДАА ГАДААДААС МӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ЗААВАР

Та СВИФТ санхүүгийн сүлжээнд бүртгэлтэй дэлхийн 200 гаруй улсын банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан Чингис хаан банкны данс руу мөнгө шилжүүлж ажлын 1-2 хоногт хүлээн авах боломжтой. Данс руу гадаадаас гуйвуулга илгээхдээ дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:

- Хүлээн авагчийн бүтэн овог нэр, дансны дугаарыг латин үсгээр бичнэ. /RUB бол кирил үсгээр/;
- Хүлээн авагчийн банкны нэр: Chinggis Khaan Bank, Банкны СВИФТ код /SWIFT/: CNKHMNUB;

Шилжүүлэгч нь аль банкнаас гуйвуулга илгээхээс хамаарч:

- Чингис Хаан Банктай корреспондент харилцаатай банкнаас гуйвуулга илгээх (Та <https://www.ckbank.mn/product/25> холбоосоор орж корреспондент банкны мэдээллийг үзнэ үү).
- Бусад банкнаас гуйвуулгыг илгээх (Та <https://www.ckbank.mn/product/28> холбоосоор орж шилжүүлэх валюттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү).

Гадаад гуйвуулга хүлээн авахад анхаарах зүйлс:

- Гадаад гуйвуулга харилцах болон картын дансанд хүлээн авахад шимтгэлгүй.
- Дансны мэдээлэл дутуу, зөрүүтэй шалтгаанаар гуйвуулга саатах, буцаагдах, нэмэлт шимтгэл, зардал төлөхөөс сэргийлж доорх зөвлөмжийг анхаарна уу.
- Гадаад гуйвуулга хүлээн авах маягтыг бөглөхдөө рублийн гуйвуулгад кирил үсгээр, бусад төрлийн валютын гуйвуулгад мэдээллийг латинаар бөглөнө. Дээрх маягтууд нь тодорхой хугацаанд өөрчлөгдөх тул та гуйвуулга хүлээн авахдаа шинэчлэн шалгаж байна уу.

Гуйвуулга хүлээн авах мэдээллийг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, банкны дотоод журмын дагуу үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлсэн байна.

Гадаад гуйвуулгатай холбоотой санал, хүсэлт гарвал Чингис хаан банкны хэрэглэгчийн утас: +976-18001300 дугаар болон bank@ckbank.mn цахим хаягаар бидэнтэй холбогдоно уу.

Харилцагчийн хөрвүүлэх гэж буй валют, үнийн дүнгээс шалтгаалан банкны дилер бэлэн болон бэлэн бус ханшийг тусгайлан танд зориулан давуу нөхцөлөөр хөрвүүлэх боломжтой. Хэрэглэгчийн утас: +976-18001300 И-мейл: treasury@ckbank.mn